

## УУЛ УУРХАЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2016.01.12

### **Нэг. Стратегийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн удирдлагын талаар:**

- Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон салбарын бусад хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаа.
- Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 402 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар “Уул уурхайн яамны ажиллагааны страт еги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг батлуулсан. Мөн “Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” -тэй уялдуулан яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратегийг Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна.
- Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүрэг, эдийн засаг, нийгмийг өгжүүлэх үндсэн чиглэл, салбарын бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомжтой уялдуулан боловсруулж батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг ханган ажиллаж байна. Яамны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ болон нэгжийн менежр, төрийн жинхэнэ албан хаагчдын үр дүнгийн гэрээг байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

### **1.1.1. Төрийн албаны тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.**

#### **Үүнд:**

- Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ийн 9 “б”, 11 дэх заалтуудын дагуу Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, үйл ажиллагааны бодлого, зохицуулалтын газар, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох албан хаагчдын материалыг төрийн албаны зөвлөлд хүр гүүлж Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үндэслэн Уул уурхайн яамны өрийн нарийн бичгийн даргын тушаалаар Д.Жавхланболыг ХШҮДАГ-ын даргаар, Б.Батхүүг БХЗГ-ын даргаар, Л.Раднаасүрэнг ТБЗГ-ын даргаар, О.Цэндүрэнг СБТГ-ын даргаар тус тус томилон ажиллуулсан.
- Яамны сул ажлын байранд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтын дагуу өрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг ТАЗ -д хүргүүлэн Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар үйлийн 17.4 дэх хэсэг, өрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 46 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтад тэнцэж нөөцөд бүртгэлтэй иргэдээс сонгон шалгаруулж ТАЗ-ийн дүгнэлтийг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилон ажиллуулж байна. 2015 онд 6 ажлын байранд нөөцөөс сонгон шалгаруулж Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн нэр дэвшсэн иргэдийг томилсон.

- Монгол Улсын Өрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг үндэслэн төрийн албанд нөөцөөс томилогдох иргэдийн дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлөөс гаргуулан томилж байна.
- Хуулийн 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн яамны төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчидтай 2015 оны үр дүнгийн гэрээ байгуулан хагас бүтэн жилээр үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэсэн. 2015 онд Уул уурхайн яам 46 албан хаагчтай, Ашигт малтмалын газар 99 албан хаагчтай, Газрын тосны газар 61 албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж дүгнэснээс Уул уурхайн яамны 44 албан хаагч Үнэлгээтэй, Ашигт малтмалын газрын 102 албан хаагч А үнэлгээтэй 40 албан хаагч В үнэлгээтэй, Газрын тосны газар 54 албан хаагч А үнэлгээтэй, 7 албан хаагч В үнэлгээтэй дүгнэгдсэн байна.
- Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 5, 6 дах хэсгүүдийг үндэслэн албан тушаалын ангилал, зэрэглэл, өрийн албанд ажилласан болон тухайн албанд ажилласан хугацаа, 2014 оны үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин, үр дүнгийн гэрээний үнэлгээ, газрын хамт олны хурлын тэмдэглэлээр гаргасан шийдвэрийг үндэслэн Уул уурхайн яамны 11 төрийн захиргааны албан хаагч, Ашигт малтмалын газрын 32 төрийн захиргааны албан хаагч, Газрын тосны газрын 23 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр олгох болон ахиулах асуудлыг Өрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж санал дүгнэлт гаргуулан Уул уурхайн сайдын 2015 оны 232 дугаар тушаалаар зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгож байна.
- Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын дагуу Уул уурхайн яамны 4 албан хаагч, Ашигт малтмалын газрын 2 албан хаагч, Газрын тосны газрын 1 албан хаагчид тус тус сануулах, Уул уурхайн яамны 2 албан хаагч, Газрын тосны газрын 1 албан хаагчид 26.1.2 дахь заалтыг дагуу албан тушаалын цалинг 6 саярхал 20 хувиар бууруулах, Уул уурхайн яамны 2 албан хаагчид 26.1.3 дахь заалтыг дагуу 1 жилийн хугацаанд төрийн албанд эргэн орох эрхгүйгээр ажлаас халах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан байна.
- Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу Засгийн газрын газрын 2007 оны 354 дүгээр тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолыг үндэслэн төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээний шатлал, албан тушаалын зэрэглэлийг үндэслэн цалинг тогтоож, 35 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 35 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, 4 албан хаагчид докторын зэргийн нэмэгдэл, 6 албан хаагчид онцгой нөхцлийн нэмэгдэл үр чадварын нэмэгдлийг 2 албан хаагчид тус тус олгож байна.
- Хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу төрийн албан хаагчдад албан томилолтоор ажилласан тохиолдолд албан томилолтын зардлыг тухай бүр нь тооцон олгож байна. Мөн хуулийн 30, 31 дүгээр зүйлүүдийг Яамны хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж байна.
- Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а" заалтыг үндэслэн Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Геологийн бодлогын хэлтсийн даргын болон мөн газрын Уул уурхайн бодлогын хэлтсийн даргын, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын, Газрын тосны газрын Эдийн засаг, саях хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын, мөн газрын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтсийн даргын, Гэрээлэлт эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэшигчдийн талаар Комиссоос гаргасан дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн

хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Ажлын хэсгийн үндэслэлт, ТАЗСЗ -ийн тогтоолын хуулбарыг хавсаргав.

### **1.1.2. Төсвийн тухай хуулийн хүрээнд:**

Төсвийн төслийг боловсруулахдаа үйл ажиллагааны зорилго зорилтой нягт уялдуулан яамны харъяа байгууллагуудаас саналуудыг авч нэгтгэн ажиллаж байна. Мөн салбарын Төрийн өмчит байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай нээлтэй хэлэлцүүлэг хийж тэдний саналыг тусган ажиллаж байна. Байгууллагын тухайн жилийн өсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар олон нийтэд нээлтэй хэлбэрээр байршуулж байна. Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Сангийн яаманд хүргүүлэн тооцоо нийлж Уул уурхайн яамны [mt@mof.gov.mn](mailto:mt@mof.gov.mn) сайтад байршуулж байна. Яамны цахим хуудсанд Шилэн дансны мэдээллийг байршуулж бие даасан цэстэй байна.

Үндэсний аудитын газар санхүүгийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн байна. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 04 дүгээр сарын 24 -ний өдөр Уул уурхайн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв шударга илэрхийлэгдсэн гэж үзэж “Зөрчилгүй” гэж дүгнэсэн тухай Уул уурхайн сайдад 796 тоот албан бичгийг ирүүлсэн байна.

5 өвлөмж өгснийг үйл ажиллагаандаа мөрдөж илэрсэн зөрчил дутагдлыг арилган ажиллаж байна. Яам агентлагын 2015 оны төсвийн гүйцэтгэлийг хавсаргав.

### **1.1.3. Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд:**

"Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дуугаар зүйлийн 23.3 дахь заалт, 23.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэн УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын үндэс болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын дагуу “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийт 63 албан хаагчаас цахимаар болон цаасаар гаргуулан хянаж бүртгэж 2014 оны тайлан мэдээг хугацаанд нь АТГ-т хүргүүлсэн. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 19 этгээдээс гаргуулан авч бүртгэн холбогдох материалын хамт АТГ -т хүргүүлэн хянуулж шийдвэрлүүлсэн. “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 26 албан хаагчаас гаргуулан хянаж бүртгэсэн байна.

Яамны албан хаагчдын дунд хаагчдад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар сургалт явуулж нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлагыг тарааж өгсөн.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, бусад хууль тогтоомжуудыг яам, агентлагын цахим хуудас болон дотоод өгжөө, E -оффист байршуулсан.

### **1.1.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд:**

Уул уурхайн яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар ажиллах журмыг Уул уурхайн сайдын 2013 оны 09 сарын 24-ны өдрийн 192 дугаар тушаалаар байгуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендерийн орон тоо өвлөсөн 3 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны өлөвлөгөөг үндэслэн 2013-2016 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан эхний хуралдаанаар батлан ажиллаж байна. 2015 онд зохион байгуулагдсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үйл явцтай холбогдуулсан Жендерийн мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөх 2 удаагийн сургалтанд хамрагдсан.

Яамны хэмжээнд жендерийн эрх тэгш байдлын харьцаа нийт албан хаагчдийн 62 хувь нь эрэгтэй, 38 хувь нь эмэгтэй байна. Удирдах ажилтны жендерийн харьцааны хувьд агентлагын дарга 1, яамны газрын даргынүүрэг гүйцэтгэгч 1, агентлагын хэлтсийн даргаар 5 эмэгтэй тус тус ажиллаж байна.

## **1.2. Төсвийн шууд захирагчийн, менежерийн, төрийн албан хаагчийн 2015 оны үр дүгийн гэрээ байгуулсан болон түүний биелэлтийг дүгнэсэн байдал:**

1.2.1. Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн яам, агентлагын төсвийн шууд захирагч болон тари йн жинхэнэ албан хаагчидтай 2015 оны үр дүнгийн гэрээ байгуулан хагас бүтэн жилээр үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэсэн.

Уул уурхайн яам болон Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Уул уурхайн албаны төсвийн шууд захирагч нар нь Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Уул уурхайн сайдтай 2015 онд үр дүнгийн гэрээ байгуулан гэрээнд байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажилүйлчилгээ 2015 оны үйл ажиллагааны өлөвлөгөөг гэрээний салшгүй хэсэг болгон нийт болон тусгай ажилүйлчилгээнүүд, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-үүд болон бусад эрх үүргийг тусган хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож үнэлэлт өгч ажилласан. Төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг сайдын зөвлөлийн хурал болон Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

1.2.2. Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын нэгжийн менежер нь төсвийн шууд захирагчтай, Төрийн албан хаагчид нь тухайн нэгжийн менежертэйгээ 2015 оны үр дүнгийн гэрээг байгуулан гэрээнд байгууллагын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний гэрээнд хэрэгжүүлэх нийт болон тусгай ажил, үйлчилгээнүүд, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-үүд болон бусад эрх үүргийг тусган гэрээний хэрэгжилтийг "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын дагуу хагас бүтэн жилээр дүгнэж дүнг Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

1.2.3. Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежер, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг 2012 оны 134-д тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл

ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам" -ыг тус тус үндэслэн хагас бүтэн жилээр дүгнэж, ажлын үр дүнтэй нь уялдуулан үр дүнгийн урамшуулал болон зарим албан хаагчдыг шагнаж урамшуулах, зэрэг дэвийг нь ахиулах зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежерүүдийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, хэлтсүүд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Төрийн нарийн бичгийн дарга болон агентлагын даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгснөөс гадна яамны Төрийн захиргааны удирдлагын газраас хуваарь гаргаж, газар, хэлтэс, агентлагуудын 2015 оны жилийн эцсийн тайлангийн хурлыг яаманд зохион байгуулж хуралд яамны сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар оролцож тайлантай танилцаж үнэлгээ өгсөн.

## **Хоёр. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн талаар:**

### 2.1 Байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн гүйцэтгэл

#### Уул уурхайн яам:

1. Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг өрийн нарийн бичгийн даргын 2015 оны 64 үдээр тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Тус яам нь зох ион байгуулалтын бүтцийн хувьд 5 газар, 4 хэлтэстэй. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын газар / Гадаад хамтын ажиллагааны хэлтэс гэсэн нэгжтэй/
- Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар /Геологийн бодлогын хэлтэс, Уул уурхайн бодлогын хэлтэс, Эдийн засаг, хөрнгө оруулалтын хэлтэс гэсэн нэгжтэй/
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Түлшний бодлого, зохицуулалтын газар
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Уул уурхайн яамны орон тоо бүтцийг хүснэгтээр үзүүлвэл:

№	Бүтцийн нэгж	Батлагдсан орон тоо	Одоо ажиллаж байгаа
1	Яамны удирдлага	3	2
2	Сайдын ажлын алба	5	4
3	Төрийн захиргааны удирдлагын газар	15	16
4	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	4	3
5	Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар	2	1
6	Геологийн бодлогын хэлтэс	6	6
7	Уул уурхайн бодлогын хэлтэс	5	4
8	Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс	5	5
9	Түлшний бодлого зохицуулалтын газар	7	7
10	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	8	8
11	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	7	5
	<b>Дүн</b>	<b>66</b>	<b>61</b>

"Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн 2.3.-т " Уул уурхайн яамны эрхэм зорилго нь Монгол Улсын нийгэм эдийн засгийн өргжилд уул уурхайн салбарын оролцоог үлэмж нэмэгдүүлж, хүний эрүүл,

аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино." гэж тодорхойлсон.

Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлж байна. Үүнд:

3.3.1. Стратегийн бодлого, өлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нийл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд геологи, уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээж, уул уурхайн эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын т свийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохицуулах, үйлчилгээ үзүүлэх, геологийн талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратегийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах, уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын нэгж, геологийн бодлогын нэгж, уул уурхайн бодлогын нэгж ажиллана.

3.3.2. Үлшний бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэрийн бодлого, техник технологийн асуудал, газрын тос, уламжлалт бус газрын тос, хий, нүүрс (эрчим хүчний нүүрснээс бусад) газрын тосны бүтээгдэхүүний хангамж зэрэг үлшний болон агаарын бохирдлыг бууруулах талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд, богино хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ үндсэн үүргийн хүрээнд нүүрс боловсруулах бодлого, техник технологийн асуудал, нүүрс (эрчим хүчний нүүрснээс бусад)-ийн хангамж, нүүрсийг олборлох, баяжуулах, хагас, гүн боловсруулах, экспортлох болон агаарын бохирдлыг бууруулах бодлогыг төлөвлөх, боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ, хэлцэл, эрэх, хайх, олборлох, боловсруулах үйлдвэрлэл, экспортлох болон шатахууны хангамж, нийлүүлэлт, газрын тос ба хийн шугам хоолойтой холбоотой бодлогыг төлөвлөх, боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, байгалийн хий, уламжлалт бус газрын тосыг эрэх, хайх, олборлох болон шингэрүүлсэн шатдаг хийн хангамж үйлчилгээ, био үлшний үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх, хий үйлдвэрлэх бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

3.3.3. Төрийн захиргааны удирдлагын бодлого хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нийл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө өгөх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, мэдээллийн технологийн дотоод дэмжлэг үзүүлэх, яамны дотоод урсгал зардал болон үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, зарцуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, үсгийн тайлан гаргах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагаан гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах, төлөвлөх, зохион байгуулах, хууль тогтоомжийн арилгах талаар хуулийн төсөл боловсруулах,

салбарын гадаад хамтын ажиллагааг өгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээн ий талаар гадаад орон, олон улсын эрх з туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хуулийн нэгж, гадаад хамтын ажиллагааны нэгж ажиллана.

3.3.4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн зорилтын 4 дүгээр зорилтын хүрээнд хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг төлөвлөх, гэрээ хэлцэлд бэлтгэх, гэрээт аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг зохицуулах, улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

3.3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрдслийн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлж дүгнэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, гэрээний хэрэгжилт болон иргэд, байгууллагын гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт гаргах, яам, агентлаг, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагуудын үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үйл ажиллагааны тайланд хяналт - шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргах, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах чиг үүрэг хүлээнэ.

#### Ашигт малтмалын газар

Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүс нутгийн геологи, геохими, гидрогеологийн зураглал, геофизикийн судалгаа хийх
- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын з тогтол, хэлбэршилтийн судалгаа хийж, эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ өгөх
- Эдийн засаг, нийгмийн үнэ хүрээнд байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд геоэкологийн судалгаа хийж үнэлгээ өгөх
- нууцын зэрэглэлд хамруулснаас бусад геологи, уул уурхайн мэдээлэл, энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өгсөн мэдээллийг сонирхсон этгээдэд хүргэх;
- үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;

- хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар хяналт тавих;
- ашигт малтмалын тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх;
- уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
- уул уурхайн салбарт өрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тухайн үед үүссэн нөхцөл байдалд үнэлэлт өгөх;
- уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах
- уул уурхайн үйлдвэрлэлийн үнийг судлах, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлвийг тодорхойлох;
- уул уурхайн үйлдвэрлэлийн тодорхой төслийг хэрэгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжүүлэх;
- улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хуримтлал бүхий талбайд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах;
- хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих:
- цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өргөлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн боловхонд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өргөлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх;
- тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх;
- тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэл хөтлөх;
- цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өргөлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
- үйлчилгээний хөлс, цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өргөлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хураан авах;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд гарсан хилийн маргааныг хянан шийдвэрлэх;
- сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх.

Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолоор АМГ-ыг 145 орон тоотой байхаар бүтцийг баталсан. АМГ-ын бүтэц нь Газрын дарга, дэд дарга, 6 хэлтэс, 1 албатай ажиллагаа явуулж байна. АМГ нь батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулан төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулан ажилласан. /Төсвийн гүйцэтгэлийг хавсаргав./

#### Ашигт малтмалын газрын орон тоо

№	Хэлтэс , удирдах ажил	Батлагдсан орон тоо	Одоо ажиллаж байгаа
1	Дарга	1	1
2	Дэд дарга	1	1



3	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	28	28
4	Геологийн алба	35	34
5	Уул уурхайн хэлтэс	25	24
6	Нүүрсний хэлтэс	16	16
7	Уул уурхайн шинжилгээ, туршилтын лаборатори	6	6
8	Кадастрын хэлтэс	17	17
9	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээллийн хэлтэс	10	9
10	Эрх зүйн хэлтэс	6	6
	<b>Нийт</b>	<b>145</b>	<b>143</b>

### Газрын тосны газар

Газрын тосны газар нь Дарга, Орлогч дарга, Захиргаа удирдлагын хэлтэс, Гэрээлэлт, эрх зүйн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хайгуул судалгааны хэлтэс, Ашиглалт, олборлолтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн хэлтэс, Үйлдвэрлэл, техник технологийн хэлтэс гэсэн зохион байгуулалтын нэгжтэй, 95 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаагийн 61 нь төрийн захиргааны албан хаагч, 34 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

Газрын тосны газрын орон тоо

№	Бүтцийн нэгж	Батлагдсан орон тоо	Одоо ажиллаж байгаа
1	Дарга	1	1
2	Орлогч дарга	1	1
3	Захиргаа удирдлагын хэлтэс	18	18
4	Гэрээлэлт эрх зүйн хэлтэс	4	4
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	6	6
6	Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	9	9
7	Хайгуул судалгааны хэлтэс	19	19
8	Ашиглалт, олборлолтын хэлтэс	15	15
9	Газрын тосны бүтээгдэхүүн ий хангамжийн хэлтэс	11	11
10	Үйлдвэрлэл, техник технологийн хэлтэс	11	11
	<b>Нийт</b>	<b>95</b>	<b>95</b>

Тус газар нь Уул уурхайн сайдын 2015 оны 19 дүгээр тушаалаар Зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч, бүтцээ шинэчлэн баталж дараах байдлаар үндсэн чиг үүргээ тодорхойлон ажиллаж байна. Үүнд:

Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Хайгуулын судалгааны асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Ашиглалт, олборлолтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Үйлдвэрлэл, техник технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Бүтэц зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвч, төсвийн гүйцэтгэлийг хавсаргав.

## **2.2. Байгууллагын боловсон хүчний хэрэгцээний төлөвлөлт, нөхөн хангалт, хүний нөөцийн төлөвлөлт, мэргэшлийн шалгалт, нөөц бүрдүүлэлт**

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Засгийн газрын 2014 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан орон тоо бүхий хэмжээнд боловсон хүчний хэрэгцээгээ төлөвлөн сонгон шалгаруулалтаар нөөц бүрдүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралтын жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ийн 9 "б", 11 дэх заалтуудын дагуу Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Шиний бодлого, зохицуулалтын газар, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох албан хаагчдын материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үндэслэн Д.Жавхланболыг ХШУДАГ-ын даргаар, Б.Батжүг БХЗГ-ын даргаар, Л.Раднаафрэнг ТБЗГ-ын даргаар, О.Цэндсүрэнг СБТГ-ын даргаар тус тус томилсон.

Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан өрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а", заалтыг үндэслэн яамны, Геологийн бодлогын хэлтэс, Уул уурхайн бодлогын хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалд болон Газрын тосны газрын Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Газрын тосны үзээгдэхүүний хангамжийн хэлтсийн дарга, Гэрээлэлт, эрх зүйн хэлтсийн дарга нарын албан тушаалд нэр дэвшигчдийн талаар ажлын хэсгээс гаргасан үндэслэлийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүр сарын 03 -ны өдрийн 46 дугаар тушаалаар Яамны зохион байгуулалтын нэгжийн ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан 59 ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, өрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

## **2.3. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилт**

Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 56 дугаар тушаалаар "Уул уурхайн яамны өрийн албан хаагчдын сургалтын журам" -ыг батлан хэрэгжүүлж байна. Сургалтын журмаар яамны төрийн албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх зорилгоор дотоод, гадаадад богино, дунд, урт хугацааны сургалтад хамруулж сургах, яамны захиалгаар мэргэжилтэн бэлтгэх, суралцуулах асуудлыг зохицуулж байна.

2015 онд Уул уурхайн яамнаас богино хугацааны сургалт, семинарт гадаадад 75, дотоодод 56 албан хаагч, дунд, урт хугацааны сургалтад гадаадад 5, дотоодод 3 албан хаагч тус тус хамрагдсан байна. Уул уурхайн сайд, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар комисс байгуулагдан Монгол Улсын Засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан "Үзээгдэхүүн хуваах гэрээ" -ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах хөрөнгийг зарцуулах журам" -ын 3 дахь хэсгийн 3.1-т заасны дагуу газрын тос, уул уурхайн салбарын чиглэлээр бакалавр болон магистрын сургалтад хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж бакалаврын сургалтад 10 иргэнийг, магистрын сургалтад 5 иргэнийг тус тус хамруулсан байна. Ажлын байранд дахь сургалт

- Яам, агентлагуудын албан хаагчдын дунд хаагчдад "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" болон "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам", Нийтийн албанд нийтийн болон

хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг өрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар 2 удаа сургалт зохион байгуулсан.

- Яамын нийт албан хаагчдад газар, хэлүүд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 9 удаагийн сургалтуудыг зохион байгуулж явуулсан.

Богино хугацааны сургалт:

- Японы Засгийн газар, ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны агентлаг хамтран Монголын Эрдэс баялгийн салбарын үндэсний нөөцийн хөгжилд чиглэсэн “Эрдэс баялаг, уул уурхайн салбарын боловсон хүчин бэлтгэх” төслийн хүрээнд Япон Улсад явагдсан 21 хоногийн сургалтад яам, Ашигт малтмалын газар боловсролын өмчит компаниудаас нийт 10 албан хаагч, Уул уурхайн яамны 2 албан хаагч 2 сарын сургалтад тус тус хамрагдсан.

## Урт хугацааны сургалт

- Монгол Улсын Засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллыг өрчлөөс суралцах иргэдийг сонгон шалгаруулах өрчлөөг зарцуулах журам” -ын 3 дахь хэсгийн 3.1-т заасны дагуу газрын тос, уул уурхайн салбарын чиглэлээр бакалавр болон магистрын сургалтад хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтыг 2014, 2015 онд зохион байгуулж бакалаврын сургалтад 25 иргэнийг, магистрын сургалтад 15 иргэнийг тус тус хамруулсан байна. Уул уурхайн яамны мэргэжилтэн Б.Мягмаржав, А.Намхайдорж, Б.Даваажаргал, ахлах мэргэжилтэн Б.Мөнхтогтох нар уг сургалтын сангийн хөрөнгөөр гадаадын их дээд сургуулиудад магистрын сургалтад хамрагдаж байна.

- Японы Олон Улсын хамтын ажиллагааны өвт “ЖАЙКА” олон улсын байгууллагын шугмаар Японы Акитагийн Их сургуульд магистрын сургалтад яамны Түлшний бодлогын газрын ахлах мэргэжилтэн П.Хүрэлхүү, Геологийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Н.Мөнх -Эрдэнэ нар хамрагдаж байна.

- Австралийн Засгийн газрын тэтгэлэгтөлбөрт эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Н.Оюундэлгэр, Япон Улсын Лэбелбөрийн хүрээнд Түлшний бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Г.Пүрэвдорж нар магистрын сургалтад хамрагдсан.

Ашигт малтмалын газар 2015 онд 25 албан хаагчийг богино хугацааны, 2 албан хаагчийг дунд хугацааны, 12 албан хаагчийг урт хугацааны сургалтад хамруулж, 31000 т зарцуулсан байна.

Газрын тосны газар 2015 онд 4 албан хаагчийг богино хугацааны, 20 албан гаачийг дунд хугацааны, 5 албан хаагчийг урт хугацааны сургалтад хамруулж 38168138 төгрөгийг зарцуулсан байна.

## 2.5. Маргааныг хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хянан шийдвэрлэх ажлын явц үр дүнгийн талаар:

Уул уурхайн яам, агентлагуудын дэргэд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны 01 дүгээр тогтоолоор Ёс зүйн хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавин Ёс зүйн хороонд 2015 онд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 1 гомдол мэдээлэл ирснийг хэлэлцэж дүгнэлт гаргасан байна. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын дагуу Уул уурхайн яамны 3 албан хаагч, Ашигт малтмалын газрын 2 албан хаагч, Газрын тосны газрын 1 албан хаагчид тус тус сануулах, Уул уурхайн яамны 2, Газрын тосны газрын 1 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26.1.2 дахь заалтыг дагуу албан тушаалын цалинг 6 сард 20 хувиар бууруулах, Уул уурхайн яамны 2 албан хаагчид мөн хуулийн 26.1.3 дахь заалтыг үндэслэн төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр ажлаас халах сахилгын шийтгэлийг ногдуулсан байна. Холбогдох мэдээ тайланг хавсаргав.

## **Гурав. Удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх болон мэдээллийн технологийг хэрэгжүүлэх талаар:**

Уул уурхайн яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газарын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Дэмчигсүрэн 2015 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдөр хүртэл хугацаанд БНСУ-ын нийслэл Өүл хотод “Южин” олон улсын сургалтын төвд “Төрийн албаны удирдлагын түвшний хүний нөөцийн хөгжил” сэдэвт сургалтад хамрагдлаа.

Сургалтыг Төрийн албаны зөвлөл, “Далайн салхи” нийгэмлэг, Олон Улсын мэргэжлийн хөгжлийн институтээс зохион байгууллаа. Үжий нөөцийн хөгжлийн тухай ойлголт”, “Ажил үүргийн анализ”, “Чадвар чадамжийн загварчлалын жишээ”, “дадлагын ажил” гэсэн сэдвээр 5 бүтэн өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг өрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь гаргаж цахимаар хүргүүлсэн.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны программ хангамж, техник хангамж, олжээг бүрэн ашиглаж байна. 2015 оны өрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан ТАЗ-өөс гаргасан хуваарийн хугацаанд хүргүүлсэн.

Яамны Эбле программд хүний нөөцийн удирдлагын программыг суулгаж мэдээллийг тогтмол ашиглаж байна. Энэж программаар ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл , тайлан мэдээ, үүрэг даалгавар түүний биелэлт, ажлын цагийн ашиглалт, хууль, эрхүйн мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, форум хэлэлцүлэг, архив бичиг хэрэг зэрэг олон мэдээллийг авах харилцах боломж бүрдсэн. Уул уурхайн яамны m.m.gov.mn цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдал цэс нээжөрийн албаны тухай хууль болонөрийн албаны холбогдох дүрэм журмыг тогтмол байршуулж байна.

Харъяа агентлаг, байгууллагуудыг байнга мэргэжил арүйн удирдлагаар хангаж, зохион байгуулалтын өрнхий бүдүүвч, бүтцийг сайдын тушаалаар батлан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас АМГ, ГТГ-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж тухай бүр нь зөвлөмж өгч ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн хувийн хэрэг өглөх журам" -ын дагуу яам, агентлагуудын өрийн албан хаагчдын хувийн хэргийг өтлөж хувийн хэрэгт Ажлын байрны тодорхойлолт, анкет,их, дээд сургууль төгссөн дипломын баталгаажсан хуулбар, 3 үеийн түүх, төрийн жинхэнэ албанд хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг нотлох баримт биүүд, албан тушаалд томилсон шийдвэр, Тангарагын хуудас зэргийг бүрдүүлэн хүн тус бүр дээр хавтас нээж хадгалж байна. Хувийн хэрэгт тухай бүр баяжилт хийж байна.

## **Дөрөв. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар:**

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлж ажиллалаа.

Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд яам, агентлагын түвшинд сургалтын өтөлбөр боловсруулан төрийн албан хаагчдад ажлын байранд сургалт зохион байгуулахын зэрэгцээ, гадаад, дотоодын урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулж байна. Салбар зөвлөлийн хуралдааныг 2 удаа хийж салбар зөвлөлийн хуралдааны дэг, салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хэлэлцэж салбар зөвлөлийн тогтоолоор батлан мөрдөн ажиллаж байна.

Салбар өвлөлийн хуралдаануудаар Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын дүн, Төрийн албан хаагчдын зэрэг дэв олгох тухай ажлын хэсгийн дүгнэлт, Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт

зохион байгуулах ажлын хэсэг байгуулах зэрэг асуудлуудыг хэлэлцэж тогтоол д гаргасан.

Салбар зөвлөлөөс байгуулсан ажлын хэсэг яам агентлагын төрийн албан хаагчдад өмнө нь олгосон зэрэг, дэвүүний нэмэгдлийн олголтын байдалд шалгалт хийж зөрчлийг арилган Салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг нь УИХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а” заалтыг үндэслэн яамны хэлтсийн дарга нар болон Газрын тосны газрын хэлтсийн дарга нарын сонгон шалгаруулалтыг явуулж дүгнэлт гарган Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нэр дэвүүлж томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгосон. Тогтоол, дүгнэлтийг хавсаргав.

Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийг Уул уурхайн яамны цахим хуудас болон яамны мэдээллийн самбарт тогтмол байршуулан ил тод мэдээллэсэн. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан зөвлөлөөс гарсан тогтоол, дүрэм, журам, зааврыг яамны дотоод сүлжээнд байршуулан төрийн албан хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан. Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН: САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ДЭМЧИГСҮРЭН

## УУЛ УУРХАЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2014.01.14

### Нэг. Стратегийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн удирдлагын талаар:

1.1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам заавруудыг үйл ажиллагаан даа мөрдлөг болгон ажиллалаа.

#### 1.1.1. Төрийн албаны тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ийн 9 "б", 11 дэх заалтуудын дагуу Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Дашдаваагийн Батболд, Бүххуягийн Мөнхтогтох нарыг сонгон шалгаруулалтад оруулахаар Төрийн албаны зөвлөлд материалыг нь хүргүүлж Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 68 дугаар тогтоолыг үндэслэн Дашдаваагийн Батболдыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд, Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Батаагийн Батжүү, Дугарсүрэнгийн Отгонлхагва нарыг сонгон шалгаруулалтад оруулахаар Төрийн албаны зөвлөлд материалыг нь хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 65 дугаар тушаалыг үндэслэн Батаагийн Батжүү Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 96 дугаар тушаалаар яамны Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд тус тус томилон ажиллуулж байна.
- Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг үндэслэн төрийн албанд юэцөөс томилогдох иргэдийн дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлөөс гаргуулан томилж байна.
- Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг хангасан төрийн захиргааны албан хаагчдыг Монгол Улсын Төрийн захиргааны албан хаагчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын дагуу Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх арга хэмжээг Газрын тосны газарт зохион байгуулсан.
- Хуулийн 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн яамны төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчидтай 2014 оны үр дүнгийн гэрээ байгуулан хагас жилээр үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэсэн.
- Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох

журам"-ын 5, 6 дах хэсгүүдийг үндэслэн албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн албанд ажилласан болон тухайн албанд ажилласан хугацаа, 2013 оны үйл ажиллагаа, мэргэшлийн үвшин, үр дүнгийн гэрээний үнэлгээ, газрын хамт олны хурлын тэмдэглэлээр гаргасан шийдвэрийг үндэслэн Уул уурхайн яамны 15 төрийн захиргааны албан хаагч, Ашигт малтмалын газрын 29 төрийн захиргааны албан хаагч, Газрын тосны 12 төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэвийг шинээр олгох болон ахиулах асуудлыг Төрийн албаны салбар өвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 22 -ны өдрийн сарын 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж санал дүгнэлт гаргуулан Уул уурхайн сайдын тушаалаар зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна.

- Уул уурхайн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна. Ёс зүйн хороо нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавин "Уул уурхайн яамны ажилтан, албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийг шинээр боловсруулан төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 136 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Яамны газар, хэлтсийн дарга нарын сайдтай байгуулсан батламж гэрээний хэрэгжилтийг хагас жилээр дүгнэж үр дүнгийн нь тооцон ажиллаж байна. "Төрийн албан хаагчийн ёс зүй" гэсэн сэдвээр Удирдлагын академитай хамтран яамны албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Ёс зүйн хороонд 2014 онд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирснийг Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын дагуу Уул уурхайн яамны 4 албан хаагч, **Ашигт малтмалын газрын 24 албан хаагч**, Газрын тосны газрын 2 албан хаагчид тус тус сануулах сахилгын шийтгэлийг ноогдуулсан байна
- Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу Засгийн газрын газрын 2007 оны 354 дүгээр тогтоол болон Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдын албан тушаалын цалингүй ажлын шатлал, албан тушаалын зэрэглэлийг үндэслэн цалинг шинэчлэн тогтоож, 32 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 33 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, 5 албан хаагчид докторын зэргийн нэмэгдэл, 7 албан хаагчид онцгой өмжлийн нэмэгдэл ур чадварын нэмэгдлийг 3 албан хаагчид тус тус олгож байна. Хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу төрийн албан хаагчдад албан томилолтоор ажилласан тохиолдолд албан томилолтын зардлыг тухай бүр нь тооцон олгож байна. Мөн хуулийн 30, 31 дүгээр зүйлүүдийг Яамны хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж байна.
- Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд УИХ -ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а", "в" заалтыг үндэслэн яамны хэлтсийн дарга нар болон Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын хэлтэс, тасгийн дарга нарын албан тушаалд нэр дэвшсэн иргэдийн сонгон шалгаруулалтыг зарлан явуулж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

### **1.1.2. Төсвийн тухай хуулийн хүрээнд:**

Төсвийн төслийг боловсруулахдаа үйл ажиллагааны зорилго зорилтой нягт уялдуулан яамны харъяа байгууллагуудаас саналуудыг авч нэгтгэн ажиллаж байна. Мөн салбарын Төрийн өмчит байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай нээлтэй хэлэлцүүлэг хийж тэдний саналыг тусган ажиллаж байна. Байгууллагын тухайн жилийн өвчт урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /[www.iltod.gov.mn/](http://www.iltod.gov.mn/) цахим хуудсаар олон нийтэд нээлтэй хэлбэрээр байршуулж байна. Сайдын багц төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Сангийн яаманд хүргүүлэн тооцоо нийлж Уул уурхайн яамны [mtm@mof.gov.mn](mailto:mtm@mof.gov.mn) сайтад байршуулж байна.

Үүнд: Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Улс өвчлөл хийгдэх геологи судалгааны ажил, Төсвийн хөрөнгө оруулалт, Геологи мэдээллийн төв, Уул уурхайн аврах алба зэрэг болно.

2013 оны жилийн эцсийн болон 2014 оны эхний хагас жилийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайлан балансын Үндэсний аудитын газраар баталгаажуулан, аудитын дүгнэлтийн хамт УУЯ-ны цахим хуудсанд байршуулж байна. Уул уурхайн яамны урсгал санхүүжилтийн урсгалыг хянах үргүй зардлыг багасгах, мэдээллийг ил тод болгох зорилгоор санхүүгийн хяналтын “Монета” шинэ программ нэвтрүүлэн ажиллаж байна.

### **1.1.3. Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд:**

"Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалт, 23.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэн УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын үндэс болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын дагуу “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийт 82 албан хаагчаас цахимаар болон цаасаар гаргуулан хянаж бүртгэснээс 17 нь ажилд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ээ гаргасан байна. ХАСХОМ-ийн 2013 оны тайлан мэдээг хуульд заасан хугацаанд гаргаж АТГ-т хүргүүлсэн.

2014 онд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 19 этгээдээс гаргуулан авч бүртгэн холбогдох материалын хамт АТГ-т хүргүүлэн хянуулж шийдвэрлүүлсэн. “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 11 албан хаагчаас гаргуулан хянаж бүртгэсэн байна.

Яамны албан хаагчдын дунд хаагчдад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар сургалт явуулсан.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, бусад хууль тогтоомжуудыг яамны цахим хуудас болон үндэсний төв -оффист байршуулсан.

### **1.1.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд:**

Уул уурхайн яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар ажиллах журмыг Уул уурхайн сайдын 2013 оны 09 сарын 24-ны өдрийн 192 дугаар тушаалаар байгуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендерийн орон тооны төлөвөөс Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн 2013 -2016 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан эхний хуралдаанаар батлан ажиллаж байна. 2013 онд салбарын үний нөөцийн өнөөгийн төлөв байдлын судалгаа гаргаж салбарын жендерийн харьцааны талаар томоохон мэдээллийг гаргаад байна.

2013 онд зохион байгуулагдсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үйл явцтай холбогдуулсан Жендерийн мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөх 2 удаагийн сургалтанд хамрагдсан.



Яамны хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлын харьцаа нийт албан хаагчдийн 65 хувь нь эрэгтэй, 35 хувь нь эмэгтэй байна. Удирдах ажилтны жендэрийн харьцааны хувьд салбарын онцлогоос хамааран эмэгтэй удирдах ажилтан байхгүй байна.

## **1.2. Төсвийн шууд захирагчийн, менежерийн, төрийн албан хаагчийн 2014 оны үр дүгийн гэрээ байгуулсан болон түүний биелэлтийг дүгнэсэн байдал:**

1.2.1. Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоо лоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн яам, агентлагын төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчидтай 2014 оны үр дүгийн гэрээ байгуулан эхний хагас жилээр үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэсэн.

Уул уурхайн яам болон Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Уул уурхайн албаны төсвийн шууд захирагч нар нь Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Уул уурхайн сайдтай 2014 онд үр дүгийн гэрээ байгуулан гэрээнд байгууллагын стратегийн зорилтыг ханга хад чиглэсэн ажилүйлчилгээ 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гэрээний салшгүй хэсэг болгон нийт болон тусгай ажилүйлчилгээнүүд, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-үүд болон бусад эрх үүргийг тусган хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож үнэлэлт өгч ажилласан. Төсвийн шууд захирагч нарын үр дүгийн гэрээний хэрэгжилтэд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг сайдын зөвлөлийн хурал болон Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

1.2.2. Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын нэгжийн менежер нь төсвийн шууд захирагчтай, Төрийн албан хаагчид нь тухайн нэгжийн менежертэйгээ 2014 оны үр дүгийн гэрээг байгуулан гэрээнд байгууллагын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнийг хэрэгжүүлэх нийт болон тусгай ажил, үйлчилгээнүүд, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-үүд болон бусад эрх үүргийг тусган гэрээний хэрэгжилтийг "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын дагуу хагас бүтэн жилээр дүгнэж дүнг Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

1.2.3. Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежер, төрийн албан хаагчдын үр дүгийн гэрээг 2012 оны 134-д тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн хагас бүтэн жилээр дүгнэж, ажлын үр дүнтэй нь уялдуулан үр дүгийн урамшуулал болон зарим албан хаагчдыг шагнаж урамшуулах, зэрэг дэвийг нь ахиулах зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежерүүдийн үр дүгийн гэрээний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, хэлтсүүд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Төрийн нарийн бичгийн дарга болон агентлагын даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Мөн албан хаагчдын үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг оновчтой төлөвлөж, гүйцэтгэлийг бодитоор үнэлж, дүгнэх, ажлын чанар үр дүнг дээшлүүлж, ажлын цагийн ашиглалтыг сайжруулан, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Уул уурхайн яамны төрийн албан хаагчдын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам"-ыг Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 139 үдээр тушаалаар батлан яамны нэгжийн удирдах албан тушаалтан, албан хаагчдын яамны хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байдал, ажлын цагийн ашиглалт, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хариутай бичгийн шийдвэрлэлт, удирдах албан тушаалтнуудын хамт олонилгээ зэрэг үзүүлэлтүүдээр дотоод үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэж байна.

## **Хоёр. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн талаар:**

2.1 Байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн гүйцэтгэл

### Уул уурхайн яам:

2. Засгийн газрын 2014 оны 382 дугаар тогтоолоор яам нь зохион байгуулалтын бүтцийн хувьд 5 газар, 4 хэлтэстэй. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын газар / Гадаад хамтын ажиллагааны хэлтэс гэсэн нэгжтэй/
- Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар /Геологийн бодлогын хэлтэс, Уул уурхайн бодлогын хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс гэсэн 3 нэгжтэй/
- Түлшний бодлого, зохицуулалтын газар
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

"Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн 2.3.-т " Уул уурхайн яамны эрхэм зорилго нь Монгол Улсын нийгэм эдийн засгийн өгжилд уул уурхайн салбарын оролцоог үлэмж нэмэгдүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино." гэж тодорхойлсон.

Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Стратегийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийн хүрээнд Уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээж, уул уурхайн эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохицуулах, үйлчилгээ үзүүлэх, геологийн талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах, уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах, үлш (эрчим хүчний нүүрснээс бусад) -ний талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах чигүүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын нэгж, геологийн бодлогын нэгж, уул уурхайн бодлогын нэгж, түлшний (эрчим хүчний нүүрснээс бусад) бодлогын нэгж ажиллана.

2. Төрийн захиргааны удирдлагын бодлого хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийн хүрээнд Төрийн захиргааны болон үний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө өгөх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй

харилцах, мэдээллийн технологийн дотоод дэмжлэг үзүүлэх, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, салбарын мэргэжилтэй боловсон хүнийг бэлтгэх, сургах, давтан сургах, төлөвлөх, зохион байгуулах, хууль тогтоомж, өрчлийг арилгах талаар хуулийн төсөл боловсруулах, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хуулийн нэгж, гадаад хамтын ажиллагааны нэгж ажиллана.

3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг төлөвлөх, гэрээ хэлцэлд бэлтгэх, гэрээт аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг зохицуулах, улсын өсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрдслийн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлж дүгнэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, гэрээний хэрэгжилт болон иргэд, байгууллагын гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт гаргах, яам, агентлаг, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагуудын үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргах, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах чиг үүрэг хүлээхээр тусгасан байна.

Уул уурхайн яамны бүтцийн схемийг хавсаргав.

### Ашигт малтмалын газар

Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүс нутгийн геологи, геохими, гидрогеологийн зураглал, геофизикийн судалгаа хийх
- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын з тогтол, хэлбэршилтийн судалгаа хийж, эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ өгөх
- Эдийн засаг, нийгмийн үйл хүрээнд байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд геоэкологийн судалгаа хийж үнэлгээ өгөх
- нууцын зэрэглэлд хамруулснаас бусад геологи, уул уурхайн мэдээлэл, энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өгсөн мэдээллийг сонирхсон этгээдэд хүргэх;
- үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;
- хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар хяналт тавих;

- ашигт малтмалын тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх;
- уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
- уул уурхайн салбарт өрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тухайн үед үүссэн нөхцөл байдалд үнэлэлт өгөх;
- уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах
- уул уурхайн үбээгдэхүүний үнийг судлах, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлвийг тодорхойлох;
- уул уурхайн үйлдвэрлэлийн тодорхой төслийг хэрэгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжүүлэх;
- улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хуримтлал бүхий талбайд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах;
- хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих:
- цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн боловхонд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх;
- тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх;
- тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэл хөтлөх;
- цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
- үйлчилгээний хөлс, цацраг идэвхт ашигт малтмалаас бусад өрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хураан авах;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд гарсан хилийн маргааныг хянан шийдвэрлэх;
- сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх.

Засгийн газрын 2012 оны 43 дугаар тогтоолоор АМГ-ыг 170 орон тоотой байхаар бүтцийг баталсан. Үүний дагуу АМГ-ын дарга 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 630 дугаар тушаал гарган бүтэц , орон тоог шинэчлэн баталсан. /Тушаалыг хавсаргав/

АМГ-ын бүтэц нь Газрын дарга, дэд дарга, 6 хэлтэс, 1 албатай үйл ажиллагаа явуулж байна. АМГ нь батлагдсан өсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулан төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулан ажилласан . /Төсвийн гүйцэтгэлийг хавсаргав./

Ашигт малтмалын газрын орон тоо

№	Хэлтэс , удирдах ажил	Батлагдсан орон тоо	Одоо ажиллаж байгаа
1	Дарга	1	1
2	Дэд дарга	1	1

3	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	39	39
4	Геологийн алба	40	40
5	Уул уурхайн хэлтэс	34	34
6	Нүүрсний хэлтэс	19	18
7	Уул уурхайн шинжилгээ, туршилтын лаборатори	12	12
8	Кадастрын хэлтэс	14	14
9	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээллийн хэлтэс	10	9
	<b>Нийт</b>	<b>170</b>	<b>168</b>

### Газрын тосны газар

Газрын тосны газар нь Дарга, Орлогч дарга, Захиргаа удирдлагын хэлтэс дотроо Гэрээлэлт эрх зүйн тасаг, Техникийн үйлчилгээний төв гэсэн 2 нэгжтэй, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хайгуул судалгааны хэлтэс, Хайгуул судалгааны хэлтэс, Ашиглалт, олборлолтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн хэлтэс, Үйлдвэрлэл, техник технологийн хэлтэс дотроо Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тасагтай зохион байгуулалтын нэгжтэй 114 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаагийн 60 нь төрийн захиргааны албан хаагч, 26 нь төрийн үйлчилгээний албан хаагч 5 нь Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолын дагуу ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байна.

Газрын тосны газрын орон тоо

№	Бүтцийн нэгж	Батлагдсан орон тоо	Одоо ажиллаж байгаа
1	Дарга	1	1
2	Орлогч дарга	1	1
3	Захиргаа удирдлагын хэлтэс	9	6
4	Гэрээлэлт эрх зүйн тасаг	5	4
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	6	6
6	Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	10	10
7	Хайгуул судалгааны хэлтэс	23	18
8	Ашиглалт, олборлолтын хэлтэс	18	10
9	Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн хэлтэс	16	8
10	Үйлдвэрлэл, техник технологийн хэлтэс	13	10
11	Техникийн үйлчилгээний төв	12	17
	<b>Нийт</b>	<b>114</b>	<b>91</b>

Тус газар нь Уул уурхайн сайдын 2013 оны 19 дүгээр тушаалаар Зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч, бүтцээ шинэчлэн баталж дараах байдлаар үндсэн чиг үүргээ тодорхойлон ажиллаж байна. Үүнд:

- Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг
- Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг
- Хайгуулын судалгааны асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг
- Ашиглалт, олборлолтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

- Газрын тосны үбээгдэхүүний х ангамжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг
- Үйлдвэрлэл, техник технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Бүтэц зохион байгуулалтын бүтэц, ерөнхий бүдүүвч, төсвийн гүйцэтгэлийг хавсаргав.

## **2.2. Байгууллагын боловсон хүчний хэрэгцээний төлөвлөлт, нөхөн хангалт, хүний нөөцийн төлөвлөлт, мэргэшлийн шалгалт, нөөц бүрдүүлэлт**

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Засгийн газрын 2012 оны 14 дугаар тогтоолоор батлагдсан орон тоогийн хэмжээнд боловсон хүчний хэрэгцээгээ төлөвлөн сонгон шалгаруулалтаар нөөц бүрдүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ийн 9 “б”, 11 дэх заалтуудын дагуу Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын, Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох иргэдийг сонгон шалгаруулалтад оруулахаар Төрийн албаны зөвлөлд материалыг нь хүргүүлж Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 165 дугаар тушаалыг үндэслэн Доржсүрэнгийн Жавхланболдыг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 1 дүгээр сарын 2 -ны өдрийн 01 тоот тушаалаар яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу Чулуунцэрэнгийн Отгочулууг Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 1 дүгээр сарын 24 -ны өдрийн 14 тоот тушаалаар яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар тус тус томилон ажиллуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”, “в” заалтыг үндэслэн яамны Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Геологийн бодлогын хэлтэс, Уул уурхайн бодлогын хэлтэс, Эдийн засаг, санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн нар болон Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын хэлтэс, тасгийн дарга нарын албан тушаалд нэр дэвшсэн иргэдийн сонгон шалгаруулалтыг зарлан явуулж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 3.14-ийн “в”-д заасны дагуу Газрын тосны газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Газрын тосны үбээгдэхүүний чанарын хяналтын тасгийн даргын сул орон тооны захирагчийн Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд ил зарлан 2013 оны 6 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд сонгон шалгаруулалтад оролцох иргэдийг бүртгэн 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Уул уурхайн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолоор байгуулагдсан комисс Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар”-ыг мөрдлөг болгон сонгон шалгаруулалтыг зохион байгуулан явууллаа.

Сонгон шалгаруулалтын үдг “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 29 дэх заалтын дагуу комиссын хуралдаанаар хэлэлцүүлэн дүнг Уул уурхайн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 10, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 9, Газрын тосны үбээгдэхүүний чанарын хяналтын тасгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 1 нийт 20 иргэн бүртгүүлснээс Хяналт -шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын

хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад бүтгүүлсэн 1 иргэн сонгон шалгаруулалтад оролцохгүй болсноо албан ёсоор мэдэгдснээр 19 иргэн сонгон шалгаруулалтад орсноос сорилын шалгалтад Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 8, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 5, Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тасгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 1 нийт 14 иргэн тэнцсэн байна.

Сорилын шалгалтад тэнцсэн иргэдээс Бичгийн шалгалт, англи хэл, мэдээллийн технологи эзэмших ур чадварын шалгалт авч, Төрийн албаны стандартын тухай мэдлэг, төсөв санхүүгийн тухай мэдлэг, тухайн ажлын байрны талаарх мэдлэг, тухайн ажлын байранд хамаарах салбарын бодлого, чиглэлийн талаарх мэдлэг, тухайн иргэний ёс зүй, хүнтэй харьцах, багаар ажиллах чадавхийг тодорхойлох чиглэлээр ярилцлага хийж үнэлгээ өгсөн.

Дээрх сонгон шалгаруулалтын үн болон Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 32, 34, 39 дүгээр зүйлд заасныг үндэслэн:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орж тэнцсэн 6 иргэн, Газрын тосны газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орж тэнцсэн 4 иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, Газрын тосны газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орж тэнцсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан Чулууны Эрдэнэсайханыг Газрын тосны газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд, Газрын тосны газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орж тэнцсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан Батнасангийн Бямбацогтыг Газрын тосны газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалд, Газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орж тэнцсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан Ганболдын Зоригоог Газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тасгийн даргын албан тушаалд тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоол гарсан.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолоор Уул уурхайн яам шинээр байгуулагдаж, Засгийн газрын 2012 оны 14 дүгээр тогтоолоор Уул уурхайн яамны үндсийг шинээр баталсантай холбогдуулан яамны сул ажлын байранд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг ТАЗ-д хүргүүлэн Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 15 -ны өдрийн 46 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтад тэнцэж нэгээр гарсан болон өөцөд бүртгэлтэй иргэдийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилон ажиллуулж байна.

Мөн Газрын тосны газрын 17 ажлын байрны захиалгын Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн нийтэд нээлттэй зарлаад байна.

Яамны зохион байгуулалтын нэгжийн жил ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 64 дүгээр тушаалаар батлан мөрдөн ажиллаж байгаа ба Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 149 дүгээр тушаалаар Яамны зохион байгуулалтын нэгжийн жил ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн давхардлыг арилгах, Шинэчлэлийн Засгийн газрын жил ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах, Ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхой, оновчтой болгохоор ажиллаж байна.

Уул уурхайн яамны үний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинээр боловсруулж эхлээд байгаа эхний төсөл бэлэн болсон. Нийтийн албаны тухай хуулийн төсөл хэл элцэж байгаатай холбогдуулан хөтөлбөрийг батлуулах асуудлыг түр хүлээж байна.

Уул уурхайн салбарын үний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхайн сайдын 2012 оны 74 үд ээр тушаалаар байгуулан ажиллаж ажлын хэсгийн хүрээнд судалгааны баг ажиллуулан геологи, уул уурхай, газрын тосны салбарын байгууллага, аж ахуйн нэгдээс судалгааг авч нэгтгэн "Уул уурхайн салбарын үний нөөцийн өнөөгийн төлвө байдал" гэсэн судалгааны тайланг товхимол болгон гарган ашиглаж байна.

### **2.3. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилт**

Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 56 дугаар тушаалаар "Уул уурхайн яамны өрийн албан хаагчдын сургалтын журам" -ыг батлан хэрэгжүүлж байна. Сургалтын журмаар яамны төрийн албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх зорилгоор дотоод, гадаадад богино, дунд, урт хугацааны сургалтад хамруулж сургах, яамны захиалгаар мэргэжилтэн бэлтгэх, суралцуулах асуудлыг зохицуулж байна. 2013 онд Уул уурхайн яамнаас богино хугацааны сургалтад гадаадад 19, дотоодод 47 албан хаагч, урт хугацааны сургалтад гадаадад 3, дотоодод 5 албан хаагч тус тус хамрагдаж, сургалт семинарийн арга хэмжээнд 10.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### **Ажлын байранд дахь сургалт**

- Удирдлагын Академитай хамтран яамны албан хаагчдын "Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдал", "Байгууллагын соёл, төрийн албан хаагчийн харилцааны соёл", "Төрийн албан хаагчийн ёс зүй" гэсэн сэдвээр 6 цагийн сургалтыг зохион байгуулсан.

- Яамны албан хаагчдын дунд хаагчдад "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" болон "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын өрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулиар 3 удаа сургалт зохион байгуулсан.

- Азийн хөгжлийн банкны дэд бүтцийн төслүүд ба уул уурхайн салбарт ХДВХ /ДОХ/ -аас урьдчилан сэргийлэх төслийн сургалтад 12 албан хаагч, Германы GIZ төслөөс зохион байгуулсан "Удирдлага ба менежмент" сургалтад 15 албан хаагч тус тус хамрагдсан.

#### **Богино хугацааны сургалт:**

- "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох АЗ гэрчилгээ олгох сургалтад 20 төрийн албан хаагч хамрагдаж сертификат авсан байна.

- Монгол Улсын Засгийн газар, Хувь үний хөгжлийн институтээс зохион байгуулж байгаа "Амьдрах ухаан-амжилтын өтөч" төслийн хүрээнд сургалтыг яаманд зохион байгуулж 25 төрийн албан хаагчийг хамруулж сертификат олгосон.

- Удирдлагын академийн сургалтын өвлөлөгөөний дагуу зохион байгуулагдсан сургалтуудад яам, агентлагын газар, хэлтсийн дарга нар, ахлах мэргэжилтэн, мэргэжилтн үүдийг хамруулсан.

- Японы Засгийн газар, ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны агентлаг хамтран Монголын Эрдэс баялгийн салбарын үний нөөцийн хөгжилд чиглэсэн "Эрдэс баялаг, уул уурхайн салбарын боловсон үчин бэлтгэх" төслийн хүрээнд 2013 оны 2 дугаар сарын 18 -27-ны өдрүүдэд Япон Улсад явагдсан сургалтад яам, Ашигт малтмалын газраас 6 албан хаагч хамрагдсан.

- БНСУ-ын MUREKO-ийн шугмаар "Уул уурхайн нөхөн сэргээлтийн судалгаа, төлөвлөгөө болон зардал тооцох, гэрээ боловсруулах, хяналт тавих" сэдвээр 7 хоногийн сургалтад 8 албан хаагч, Авсралийн Сидней хотноо зохион байгуулагдсан Уул уурхай дахь усны чиглэлээр 21 хоногийн сургалтад 2 мэргэжилтэн, "Уул уурхайн эдийн засаг" сэдэвт 2 хоногийн сургалтад 1 мэргэжилтэн, БНСУ-д Солонгосын олон улсын хамтын ажиллагын байгууллага /KOIKA/-аас зохион байгуулсан 28 хоногийн сургалтад 1 албан хаагч, ХБНГУ-д зохион байгуулсан "Газрын тосны хөөцийн менежмент" сэдэвт сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.

#### **Урт хугацааны сургалт**



- Монгол Австралийн тэтгэлэгтөхөлбөрийн (МАСТХ)-ийн газрын Австралийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд магистрын сургалтад Уул уурхайн яамны Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Н.Оюундэлгэр, Ашигт малтмалын газрын Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн А.Баясгалан нар, Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Г.Энхзул япон улсад япон хэлний гүнзгийрүүлсэн сургалтад тус тус хамрагдсан.

- Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуулийн магистрт 2, хуулийн магистрт 1, геологийн чиглэлээр докторантурт 2 албан хаагч тус тус суралцаж байна.

- Ашигт малтмалын газар 2013 онд богино хугацааны сургалтад гадаадад 17 албан хаагч, дотоодын сургалтад 36 албан хаагч, дунд хугацааны сургалтад гадаадын сургалтад 6 дотоодын сургалтад 2 албан хаагч, урт хугацааны сургалтад гадаад сургалтад 2 албан хаагч, дотоод сургалтад 12 албан хаагч нийт давхардсан тоогоор гадаад дотоодын сургалтад 75 албан хаагчийг хамруулсан байна.

- Газрын тосны газар 2013 онд давхардсан тоогоор 60үж гадаадад болон дотоодод богино, дунд хугацааны дадлагажуулах онол аргийн гадаад хэлний сургалтанд хамрагдснаас гадаадад 25, дотоодод 35 ажилтан сургалтанд хамрагдсан байна. Гадаад хэлний сургалтын төвүүдэд гадаад хэлний мэдлэг, олгох, түвшин ахиулах сургалтанд нийт 18 ажилтан, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газраас “Засгийн Газрын худалдан авах ажиллагааны А-3 сургалт буюу “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт”-нд 16 ажилтан хамрагдлаа. Мөн бүх ажиллагсадыг оролцуулан 5,5 сая төгрөгийн төсөв бүхий ажлын байран дахь сургалт буюу “Багийн сургалт”-ыг 25 хүнтэй 1 багаар 3 удаа зохион байгуулж, 68 ажилтан оролцож, нийт ажиллагсдын 75 хувь хамрагдсан болно. Газрын тосны сургалтын сангийн тэтгэлэгт хамрагдан тус газартай “Урт хугацааны сургалтын гэрээ” байгуулан 3 ажилтан гадаадын их дээд сургуульд, Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хамрагдан 1 мэргэжилтэн Австрали Улсад тус тус мэргэжил дээдх урт хугацааны сургалтанд явсан.Шинээр томилогдсон ажилтнуудыг анхан шатны буюу баримжаа олгох сургалтанд хамруулах ажил тухай бүр хийгдэж хэвшсэн.

Яам, агентлагын сургалтын хөтөлбөрийг хавсаргав.

#### **2.4. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авсан арга хэмжээ, үр дүн**

"Уул уурхайн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулан Төрийн нарийн бичгийн дагын 2012 оны 79 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2013 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. /Хөтөлбөрийг хавсаргав./ Үүнд:

1. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд компьютер, тоног төхөөрөмж, тавилга шинэчлэхэд зориулж 183.2 сая төгрөг зарцуулсан.

2. Ашигт малтмалын газар компьютер, тоног төхөөрөмж, тавилга шинэчлэхэд 148.9 сая төгрөг, Газрын тосны газар конторын барилгынөргөтгөл барихад 1.54 тэрбум төгрөг, Уул уурхайн аврах алба аврах багаж, тоног төхөөрөмж шинэчлэхэд 526,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

3. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд албан хаагчдыг 8 хувийн хүүтэй орон сууцны зээлд хамрагдахад дэмжлэгүзүүлж Төрийн банкттай хамтарн ажиллах гэрээ байгуулан 500 сая төгрөгийн багц нээж 1.2 хувийн хүүтэй орон сууцны зээлд 9 албан хаагчийг хамруулахаар шийдвэрлэсэнээс 3 албан хаагч нь зээлд хамрагдаж орон сууцтай болсон ба 6 албан хаагч орон сууцны 30 хувийн урьдчилгаа төлбөрөө төлөн орон сууцаа захиалсан байна. 8 албан хаагчид нийт 3.6 сая төгрөгийн буцалтгүй тусламж 5 албан хаагчид 1.5 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан яамны Төрийн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулан, сургалт, эмчилгээний асуудлыг гэрээнд тусган энэ арга хэмжээнд 4.0 сая төгрөг, албан хаагчдын хоол,

унааны өнгөлөлтөд 45.0 сая төгрөг, шагнал урамшуулалд 5,3 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Ашигт малтмалын газар АМГ-ын даргын 2009 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 264 тоот тушаалаар агентлагийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж төлбөрийг батлан ажиллаж байна. /Хөтөлбөрийг хавсаргав/ 2013 онд Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 8 хувийн орон сууцны зээлэнд ажилтан, албан хаагчдаа хамруулан ажиллахаас гадна Голомт банкинд үсэлт гарган байгууллагын ажилтан, албан хаагчдад үзүүлэх цалингийн зээлийн нөхцлийг хөнгөрүүлж хүүг 1.7-2 хувь байсныг 1.5-1.7 хувь болгон бууруулж, зээлийн хугацааг 24 сараас 36 сар болгон уртасгуулсан. Мөн хамтран ажиллах гэрээний дагуу Улаанбаатар хотын банкинд үсэлт гарган орон сууцны 10 хувийн урьдчилгаа төлбөртэй зээл авах гэрээний үхцөлд өөрчлөлт оруулан 100 сая хүртэл зээлийг 150 сая хүртэл төг болгон нэмэгдүүлсэн. 14 хүнд 2,8 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт, 21 хүнд 3,7 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

Газрын тосны газар нь Төрийн албан хаагчийн ажлын байрны ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор конторын өргөтгөлийг бариулж байгаа ба Лабораторийн барилгыг шинээр ашиглалтанд оруулсан. Албан хаагчдын нийгмийн баталгаа болон тогтвор сууршилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл байдлыг хангах үүднээс Өвөр Зайсан дах зуслангийн газарт "Зуны зуслангийн байр" барих зориулалтаар газар олгож ажиллагаа явуулж байгаа ба энэхүү арга хэмжээ үргэлжилж байна. /Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах төлбөрийг хавсаргав/.

## **2.5. Маргааныг хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг хянан шийдвэрлэх ажлын явц үр дүнгийн талаар:**

Уул уурхайн яам, агентлагуудын дэргэд Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна. Ёс зүйн хороог Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолоор батлан Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавин "Уул уурхайн яамны ажилтан, албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийг шинээр боловсруулан өрийн нарийн бичгийн даргын 2013 оны 136 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Яамны газар, хэлтсийн дарга нарын сайдтай байгуулсан батламж гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж үр дүнгийн нь тооцон ажиллаж байна. "Төрийн албан хаагчийн ёс зүй" гэсэн сэдвээр Удирдлагын академитай хамтран яамны албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Ёс зүйн хороонд 2013 онд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой маргаан, өргөдөл, гомдол ирээгүй байна. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын дагуу Уул уурхайн яамны 3 албан хаагч, Ашигт малтмалын газрын 24 албан хаагч, Газрын тосны газрын 2 албан хаагчид тус тус сануулах, Газрын тосны газрын 3 албан хаагчид 26.1.2 дахь заалтыг дагуу албан тушаалын цалинг 6 сар хүртэл 20 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг ноогдуулсан байна. Холбогдох мэдээ тайланг хавсаргав.

## **Гурав. Удирдах ажилтны манлайлах үр чадварыг дээшлүүлэх болон мэдээллийн технологийг хэрэгжүүлэх талаар:**

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралтын жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ийн 9 "б", 11 дэх заалтуудын дагуу Уул уурхайн яамны Стратегийн бодлого, өлөвлөлтийн газрын даргын болон Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох иргэдийн материалыг өрийн албаны өвлөлд хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 165 дугаар тушаалыг үндэслэн Доржсүрэнгийн Жавхланболдыг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 01 тоот тушаалаар яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу Чулуунцэрэнгийн Отгочулууг Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны

1 дүгээр сарын 24-ны өдрийн 14 тоот тушаалаар яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар тус тус томилон ажиллуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 дахь заалтын дагуу УИХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а", "в" заалтыг үндэслэн яамны хэлтсийн дарга нар болон Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын хэлтэс, тасгийн дарга нарын албан тушаалд нэр дэвшсэн иргэдийн сонгон шалгаруулалтыг зарлан явуулж өрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Судалгааг өмнө нь ирсэн хүснэгтийн дагуу гаргаж хавсаргав.

Яамны сул ажлын байранд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг ТАЗ-д хүргүүлэн Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4 дэх хэсэг, өрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 46 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтад тэнцэж нэгээр гарсан боловч өд бүртгэлтэй иргэдийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилон ажиллуулж байна. Судалгааг өмнө нь ирсэн хүснэгтийн дагуу гаргаж хавсаргав.

Төсвийн шууд захирагч нарын манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалтын хүрээнд Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан "Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт Төрийн нарийн бичгийн дарга оролцож "Канадын төрийн алба", "Төрийн албаны мерит тогтолцоо", "Төрийн албаны шинэтгэлийн зарим асуудлууд", "Яам, агентлагын чиг үүргийн шинжилгээний чиглэлээр хийсэн судалгааг үр дүн " гэсэн сэдвээр сургалтад хамрагдсан.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг өрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь гаргаж цахимаар хүргүүлсэн.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны программ хангамж, техник хангамж, сүлжээг бүрэн ашиглаж байна. Яамны е-оффист хүний нөөцийн удирдлагын про граммыг суулгаж мэдээллийг тогтмол ашиглаж байна. Үүнээр программаар ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлан мэдээ, үүрэг даалгавар түүний биелэлт, ажлын цагийн ашиглалт, хууль, эрх зүйн мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, форум хэлэлцүүлэг, архив бичиг хэрэг зэрэг олон мэдээллийг авах харилцах боломж бүрдсэн.

Харъяа агентлаг, байгууллагуудыг байнга мэргэжил аргын удирдлагаар хангаж, зохион байгуулалтын ернхий бүдүүвч, бүтцийг сайдын тушаалаар батлан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Уул уурхайн сайдын 2013 оны 132 дугаар тушаалаар Ашигт малтмалын газрынүйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч цаашид авах арга хэмжээний талаар чиглэл өгөн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас АМГ, ГТГ-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж тухай бүр нь зөвлөмж өгч ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан өрийн албан хаагчийн хувийн хэрэг өглөх журам" -ын дагуу яам, агентлагуудын өрийн албан хаагчдын хувийн хэргийг өтлөж хувийн хэрэгт Ажлын байрны тодорхойлолт, анкет, их, дээд сургууль төгссөн дипломын баталгаажсан хуулбар, Зүеийн түүх, төрийн жинхэнэ албанд хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг нотлох баримт бичиг, албан тушаалд томилсон шийдвэр, Тангарагын хуудас зэргийг бүрдүүлэн хүн тус бүр дээр хавтас нээж хадгалж байна. Хувийн хэрэгт тухай бүр баяжилт хийж байна.

### **Дөрөв. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар:**

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлж ажиллалаа. Яамны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн

төслийн боловсруулж байна. Уул уурхайн салбарын үний нөөцийн өнөөгийн төлөв байдал судалгааны тайлан боловсруулж товхимол болгон гарган ашиглаж байна.

Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд яам, агентлагын түвшинд сургалтын жетөлбөр боловсруулан төрийн албан хаагчдад ажлын байранд сургалт зохион байгуулахын зэрэгцээ, гадаад, дотоодын урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулж байна.

Салбар зөвлөлийн хурлыг 4 удаа хийж Төрийн албан хаагчдын зэрэг дэв олгох тухай, Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх тухай, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах, Салбар зөвлөлийн гишүүдийн ажил, үүргийн хуваарийг батлах тухай, Төрийн албан хаагчдыг "Төрийн албаны тэргүүний ажилтан" хүндэт тэмгээр шагнуулахаар нэр дэвшүүлэх тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж тогтоол, дүгнэлт гаргасан.

Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийг Уул уурхайн яамны цахим хуудас болон яамны мэдээллийн самбарт тогтмол байршуулан ил тод мэдээллэсэн. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан зөвлөлөөс гарсан тогтоол, дүрэм, журам, зааврыг яамны дотоод сүлжээнд байршуулан төрийн албан хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан.

БОЛОВСРУУЛСАН: САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.ДЭМЧИГСҮРЭН